ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ДУА-2022/121/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Мандалговь хот

2022 он

Дарга,тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал
Утас: 70592225
Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Батсайхан
Утас: 70593113
Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт ...... **Error! Bookmark not defined.**
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ...... 4
3. Аудитын тайлан...... 11
3.1 Ерөнхий зүйл ...... 11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ...... 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ...... 11
3.4 Материаллаг байдал ...... 12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ...... 12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ...... 12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ...... 13
3.8 Аудитын гол асуудал ...... 14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...... 14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ...... 14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ...... 14
4. Аудитын илрүүлэлт...... 14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ...... 15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

## 1.Аудитын санал дүгнэлт

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
48090 Дундговь аймаг, Сайнцагаан сум
Утас: 70592439, 70592208, 70593208
И-мэйл: dundgovi@audit.gov.mn

2022.02.21 № 12

танай ______________ -ны № ______________ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ДАШСҮРЭН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

0012020701

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **20,566,146.38** | **172,658,725.63** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 3,522,077 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 3,522,077 |
| **3121** | **Төгрөг** | - | 3,522,077 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 326,327 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | - | 3,195,750 |
| **33** | **АВЛАГА** | - | 94,488,200 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 88,386,500 |
| **335** | **Бусад авлага** | - | 6,101,700 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 6,101,700 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 20,566,146.38 | 74,648,448.63 |
| **351** | **Түүхий эд материал** | 15,800,489.38 | 63,991,074.63 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 6,782,633.42 | 16,379,770.07 |
| 35130 | Эм боох материал | 9,017,855.96 | 47,611,304.56 |
| **354** | **Хангамжийн материал** | 4,765,657 | 10,657,374 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 238,500 | 191,500 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,860,117 | 8,649,336 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 641,100 | 1,082,950 |
| 35460 | Хүнсний материал | 1,025,940 | 733,588 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,205,838,635.05** | **1,251,890,897.17** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,205,838,635.05 | 1,251,890,897.17 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,195,315,744.05 | 1,241,634,230.45 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 978,078,920.24 | 978,078,920.24 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (52,662,851.23) | (69,814,654.75) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 30,000,000 | 30,000,000 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (24,000,000) | (30,000,000) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 104,512,573.00 | 157,889,415.36 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (60,442,460.44) | (41,405,074.64) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 30,919,067.11 | 32,877,067.11 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (11,089,504.63) | (15,991,442.87) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 200,000,000 | 200,000,000 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 10,522,891.00 | 10,256,666.72 |
| 39301 | Програм хангамж | 522,891.00 | 522,891.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - | (266,224.28) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 10,000,000 | 10,000,000 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,226,404,781.43** | **1,424,549,622.80** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,226,404,781.43** | **1,424,549,622.80** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,226,404,781.43 | 1,424,549,622.80 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 334,600,425.76 | 334,600,425.76 |
| 51101 | Өмч: - төрийн | 334,600,425.76 | 334,600,425.76 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 841,356,041.20 | 1,039,500,882.57 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 841,356,041.20 | 841,356,041.20 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 198,144,841.37 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 50,448,314.47 | 50,448,314.47 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,226,404,781.43** | **1,424,549,622.80** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **395,900,330.89** | **950,278,654.82** |

| | | | |
|---|---|---|---|
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **36,451,270.89** | **256,195,584.82** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 36,451,270.89 | 256,195,584.82 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 36,451,270.89 | 256,195,584.82 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 35,571,270.89 | 256,195,584.82 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **359,449,060** | **694,083,070** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 303,038,300 | 365,780,800 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 303,038,300 | 365,780,800 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 6,252,900 | 288,849,310 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 800,000 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,082,900 | 23,990,400 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 170,000 | 7,103,910 |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | | 256,955,000 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 33,743,000 | 32,943,000 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 33,743,000 | 32,943,000 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 16,414,860 | 6,509,960 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 16,414,860 | 6,509,960 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **415,101,544.10** | **752,133,813.45** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **415,101,544.10** | **752,133,813.45** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 406,933,972.94 | 721,599,053.15 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 237,553,488 | 314,062,340 |
| 210101 | Үндсэн цалин | 154,147,560 | 147,481,352 |
| 210102 | Нэмэгдэл | 58,597,264 | 132,082,976 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,998,000 | 3,867,000 |
| 210104 | Урамшуулал | 20,810,664 | 30,631,012 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 29,716,608 | 39,034,462 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,677,462 | 27,341,303 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,432,827 | 3,074,388 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,902,435 | 2,405,746 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 426,310 | 564,818 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,277,574 | 5,648,207 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 27,246,314.12 | 23,502,539.70 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,870,725.9 | 1,294,807.8 |
| 210302 | Түлш, халаалт | 25,054,588.22 | 21,581,431.9 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 321,000 | 626,300 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,643,390 | 32,384,776.42 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,086,700 | 2,698,200 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,677,050 | 21,145,930 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 837,900 | 1,012,000 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,915,140 | 6,211,350 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 1,317,296.42 |
| **2105** | **Нормативт зардал** | 32,936,656.47 | 248,017,332.79 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 29,996,651.35 | 232,246,015.79 |
| 210502 | Хоол, хүнс | 2,835,005.12 | 14,054,317 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 105,000 | 1,717,000 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,101,900 | 13,412,343 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,672,500 | 4,182,343 |
| 210604 | Урсгал засвар | 5,429,400 | 9,230,000 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 578,000 | 2,098,000 |
| 210702 | Дотоод албан томилолт | 578,000 | 2,098,000 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,840,878 | 2,562,506 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 589,672.00 | 327,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 79,500.00 | 79,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 61,205.60 | 62,706.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 34,500.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 360,000.00 | 828,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 100,000.00 | 100,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,400,000.00 | 1,131,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 51,316,738.75 | 46,524,753.24 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,917,850 | 2,036,000 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 48,398,888.75 | 44,488,753.24 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 8,167,571.16 | 30,534,760.3 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 30,504,300 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | - | 3,113,100 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 3,591,200 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 23,800,000.0 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,548,695.88 | 30,460.3 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,548,695.88 | 30,460.3 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(19,201,213.21)** | **198,144,841.37** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(19,201,213.21)** | **198,144,841.37** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| | | | |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **360,329,060** | **605,696,570** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **359,449,060** | **605,696,570** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 303,038,300 | 365,780,800 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 303,038,300 | 365,780,800 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 6,252,900 | 200,462,810 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 800,000 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,082,900 | 23,990,400 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 170,000 | 7,103,910 |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | | 168,568,500 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 33,743,000 | 32,943,000 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 33,743,000 | 32,943,000 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 16,414,860 | 6,509,960 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 16,414,860 | 6,509,960 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **353,697,060** | **596,181,693** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **353,697,060** | **596,181,693** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **345,529,488.84** | **565,646,932.7** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 237,553,488 | 314,062,340 |
| 210101 | Үндсэн цалин | 154,147,560 | 147,481,352 |
| 210102 | Нэмэгдэл | 58,597,264 | 132,082,976 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,998,000 | 3,867,000 |
| 210104 | Урамшуулал | 20,810,664 | 30,631,012 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 29,716,608 | 39,034,462 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,677,462 | 27,341,303 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,432,827 | 3,074,388 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,902,435 | 2,405,746 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 426,310 | 564,818 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,277,574 | 5,648,207 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 27,246,314.12 | 23,502,539.70 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,870,725.9 | 1,294,807.8 |
| 210302 | Түлш, халаалт | 25,054,588.22 | 21,581,431.9 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 321,000 | 626,300 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,089,040 | 31,591,350 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,220,700 | 2,698,200 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,343,150 | 20,157,100 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 837,900 | 1,012,000 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,560,690 | 7,724,050 |
| **2105** | **Нормативт зардал** | 19,085,411.12 | 128,030,035 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 12,236,795 | 112,843,620 |
| 210502 | Хоол, хүнс | 3,228,616.12 | 13,289,415 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,620,000 | 1,897,000 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,501,900 | 22,726,700 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 6,101,700 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,722,500 | 7,215,000 |
| 210604 | Урсгал засвар | 5,779,400 | 9,410,000 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 578,000 | 2,098,000 |
| 210702 | Дотоод албан томилолт | 578,000 | 2,098,000 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,840,877.6 | 2,565,506 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 589,672 | 327,800 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 79,500 | 79,500 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 61,206 | 62,706 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 34,500 | 33,000 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 360,000 | 828,500 |
| 210807 | Газрын төлбөр | 100,000 | 100,000 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,400,000 | 1,134,000 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,917,850 | 2,036,000 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,917,850 | 2,036,000 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **8,167,571.16** | **30,534,760.3** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 30,504,300 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | - | 3,113,100 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 3,591,200 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 23,800,000 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,548,695.88 | 30,460.3 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,548,695.88 | 30,460.3 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **6,632,000** | **9,514,877** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **6,632,000** | **5,992,800** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **6,632,000** | **5,992,800** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 6,632,000 | 5,992,800 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 6,632,000 | 5,992,800 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(6,632,000)** | **(5,992,800)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (0) | 3,522,077 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 3,522,077 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 334,600,425.76 | 50,448,314.47 | 861,460,629.41 | 1,246,509,369.64 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | -903,375.00 | -903,375.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **334,600,425.76** | **50,448,314.47** | **860,557,254.41** | 1,245,605,994.64 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -19,201,213.21 | -19,201,213.21 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **334,600,425.76** | **50,448,314.47** | **841,356,041.20** | 1,226,404,781.43 |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **334,600,425.76** | **50,448,314.47** | **841,356,041.20** | 1,226,404,781.43 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **334,600,425.76** | **50,448,314.47** | **841,356,041.20** | 1,226,404,781.43 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 198,144,841.37 | 198,144,841.37 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **334,600,425.76** | **50,448,314.47** | **1,039,500,882.57** | 1,424,549,622.80 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/ төгрөгөөр /**

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 421,633,400 | 404,876,972.7 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 421,633,400 | 404,876,972.7 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 414,929,100 | 398,172,672.7 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 245,604,400 | 241,303,429 |
| 210101 | Үндсэн цалин | 148,726,600 | 147,481,352 |
| 210102 | Нэмэгдэл | 69,693,400 | 66,694,765 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,885,000 | 3,867,000 |
| 210104 | Урамшуулал | 23,299,400 | 23,260,312 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32,556,000 | 31,773,931 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,927,800 | 22,398,104 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,555,100 | 2,492,835 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,990,300 | 1,940,508 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 462,100 | 449,312 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,620,700 | 4,493,172 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,533,000 | 23,502,539.7 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,325,200 | 1,294,807.8 |
| 210302 | Түлш, халаалт | 21,581,500 | 21,581,431.9 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 626,300 | 626,300 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22,087,400 | 22,087,400 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,451,000 | 1,451,000 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,554,800 | 15,554,800 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,012,000 | 1,012,000 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,069,600 | 4,069,600 |
| **2105** | **Нормативт зардал** | 44,886,700 | 44,886,367 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 36,555,700 | 36,555,462 |
| 210502 | Хоол, хүнс | 6,434,000 | 6,433,905 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,897,000 | 1,897,000 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 38,359,100 | 28,719,500 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 12,094,500 | 12,094,500 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 16,854,600 | 7,215,000 |
| 210604 | Урсгал засвар | 9,410,000 | 9,410,000 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,100,000 | 2,098,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,100,000 | 2,098,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,566,500 | 2,565,506 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,327,800 | 327,800 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 79,500 | 79,500 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 63,700 | 62,706 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000 | 33,000 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 828,500 | 828,500 |
| 210807 | Газрын төлбөр | 100,000 | 100,000 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,134,000 | 1,134,000 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,236,000 | 1,236,000 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,236,000 | 1,236,000 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6,704,300 | 6,704,300 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 6,704,300 | 6,704,300 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 3,113,100 | 3,113,100 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 3,591,200 | 3,591,200 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 55,852,600 | 39,422,499.7 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 32,943,000 | 32,912,539.7 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 32,943,000 | 32,912,539.7 |
| **122** | **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | 22,909,600 | 6,509,960 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 22,909,600 | 6,509,960 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 326,327.00 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | 22.00 | 19.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 21.00 | 18.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 15.00 | 12.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5.00 | 5.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **197,267,060** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **197,267,060** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 173,467,060 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 72,758,911 |
| 210102 | Нэмэгдэл | 65,388,211 |
| 210104 | Урамшуулал | 7,370,700 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 7,260,531 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,943,199 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 581,553 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 465,238 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 115,506 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,155,035 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,503,950 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,247,200 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,602,300 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,654,450 |
| **2105** | **Нормативт зардал** | 83,143,668 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 76,288,158 |
| 210502 | Хоол, хүнс | 6,855,510 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 800,000 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 800,000 |

| | | |
|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 23,800,000 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23,800,000 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 23,800,000 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 200,462,810 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 200,462,810 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 800,000 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 192,558,900 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 7,103,910 |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт | 168,568,500.00 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **3,195,750** |
| 11000 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| 12000 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 3,195,750 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Т.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төв 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 275 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төв нь эрхэм зорилгоо “ Хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй, чанартай үзүүлсэн эрүүл мэндийн боловсрол олгоход оршино ” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт, шалгалт хийгдсэн. Хяналт, шалгалтаар албан томилолтын журмыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөгдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 4 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 4 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 752,133.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,521.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,264.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 198,144.9 мянган төгрөгөөр буюу 16 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 3,522.1 | 3,522.1 |
| Авлага | - | 94,488.2 | 94,488.2 |
| Бараа материал | 20,566.1 | 74,648.4 | 54,082.3 |
| Үндсэн хөрөнгө | 1,205,838.6 | 1,251,890.9 | 46,052.3 |
| **Нийт хөрөнгө** | **1,226,404.7** | **1,424,549.6** | 198,144.9 |
| | | | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,226,404.7 | 1,424,549.6 | 198,144.9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,226,404.7** | **1,424,549.6** | 198,144.9 |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд нэмэлт санхүүжилт дансны 3,195.8 мянган төгрөг, төсвийн харилцах дансны 326.3 мянган төгрөгийн үлдэгдэл тус тус байна.

Бараа материал дансны үлдэгдэл 74,648.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 54,082.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 112,843.6 мянган төгрөг, хандив тусламжаар 141,557.2 мянган төгрөгийн эм боох материал хүлээн авсантай холбоотой байна.

Эм боох материалын дансны эцсийн үлдэгдэл 47,611.3 мянган төгрөг болж өмнөх оноос өссөн нь ковид-19 цар өвчин гарсантай холбоотойгоор вакцинжуулалт хийгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 5,992.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 84,548.2 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авч, 35,206.1 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас шилжүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,424,549.6 мянган төгрөг болж 198,144.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 578,411.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 578,411.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 156,778.0 мянган төгрөгөөр бууруулан 421,633.4 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 421,633.4 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 405,233.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, 16,399.6 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авсан нь үндсэн үйл ажиллагааны 4 тусламж үйлчилгээг ковидын нөхцөл байдлаас шалтгаалж дутуу үзүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 404,877.0 мянган төгрөг буюу 99 хувийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 30.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлж, 326.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 192,558.9 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 800.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 7,103.9 мянган төгрөг, нийт 200,462.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 9,503.9 мянган төгрөг, цалин хөлс болон нэмэгдэл урамшил 80,019.5 мянган төгрөг, нормативт зардалд 83,143.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 800.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 23,800.0 мянган төгрөг, нийт 197,267.1 мянган төгрөгийг зарцуулж 3,195.8 үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Ковид-19 цар тахал тархсантай холбоотой тайлант онд тусламж хандив, төсвийн өөрийн хөрөнгөөр нийт 289,169.4 мянган төгрөгөөр эм боох материал, хамгаалах хувцас, хэрэгсэл, эмийн багц, ковидын тест, дархлаажуулалтын вакцин худалдан авч, 239,007.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн яамнаас эм, эмийн хэрэгслүүдийг аймгийн ЭМГ-аар дамжуулан хуваарилсан байна.

Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй эм нэг бүрийн үнийг оронгийн цэг, таслалын алдаанаас 10 дахин өсгөж илүү дүнгээр нэхэмжилсэн 180 ширхэг эмийн үнэ 2,197.7 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан. алдааг аудитын явцад залруулсан.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй тул гол асуудал байхгүй гэж үзлээ.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 17 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 680,384.4 мянган төгрөгийн 137 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулснаас 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 738.2 мянган төгрөгийн төлбөрийн акт, зөрчлийг арилгах 212.2 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлэн, заасан хугацаанд хэрэгжилтийг албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан бараа материалын дансанд завсрын аудитаар хяналтын тооллого хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,309.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2,220.7 төгрөгийн алдааг залруулж, 163.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож 1,925.0 мянган төгрөгийн албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Албан томилолттой албан хаагчдад хоолны мөнгө давхардуулан 23.0 мянган төгрөг олгосон.
2. Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй эм нэг бүрийн үнийг оронгийн цэг, таслалын алдаанаас 10 дахин өсгөж илүү 2,197.7 мянган төгрөгөөр илүү нэхэмжилсэн дүнгээр бараа материалын орлогод илүү тайлагнасан.

*<u>Шийдвэрлэсэн нь:</u> Завсрын аудитын явцад нийт* 2,220.7 *мянган төгрөгийн залруулга хийсэн.*

**4.2 Төлбөрийн акт**

Аудитаар илэрсэн дараах зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Өндөр настны тэтгэвэр тогоолгоод үргэлжлүүлэн ажиллаж байгаа ажилтанд 163.3 мянган төгрөгийн түлш халаалтын хөнгөлөлт олгосон.

*<u>Шийдвэрлэсэн нь:</u> 2021 оны жилийн эцсийн санхүүгийн аудитаар дээрх зөрчилд* 163.3 *мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.*

**4.3 Албан шаардлага**

1. Зургаан нэр төрлийн 1,925.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаж тайлагнаагүй

*<u>Шийдвэрлэсэн нь</u>: 2021 оны жилийн эцсийн санхүүгийн аудитаар дээрх 1,925.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.*

**4.4 Зөвлөмж**

***1. Бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u> Завсрын аудитаар 13 нэр төрлийн 17 тоног төхөөрөмжийг бүртгэл, тайланд тусгаагүй байна.*

*<u>Өгсөн зөвлөмж</u>: Хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу бүртгэлд тусгах*

Дээрх зөвлөмжийн хүрээнд 6 нэр төрлийн 1,925.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаж тайлагнаагүй тул 2021 оны жилийн эцсийн санхүүгийн аудитаар албан шаардлага хүргүүллээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Алдаа, зөрчлийн агуулга | Нийт алдаа, зөрчлийн | | Үнэлгээ: Залруулга | | Үнэлгээ: Төлбөрийн акт | | Үнэлгээ: Албан шаардлага | | Үнэлгээ: Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:** | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| **2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:** | | | | | | | | | | | |
| 1 | 6 нэр төрлийн тоног төхөөрөмжийг бүртгэл, тайланд тусгаагүй | | | | | | | 1 | 1,925.0 | | |
| 2 | Өндөр насны тэтгэвэр тогтоолгоод үргэлжлүүлэн ажиллаж байгаа ажилтанд байгууллагаас түлшний хөнгөлөлт давхардуулан олгосон. | | | | | 1 | 163.3 | | | | |
| 3 | Албан томилолттой албан хаагчдад хоолны мөнгө давхардуулан олгосон. | | | 2 | 23.0 | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй эм нэг бүрийн үнийг оронгийн цэг, таслалын алдаанаас 10 дахин өсгөж нэхэмжилсэн илүү дүнгээр бараа материалын орлогод илүү тайлагнасан. | | | 1 | 2,197.7 | | | | | | |
| 5 | 13 нэр төрлийн 17 тоног төхөөрөмжийг бүртгэл, тайланд тусгаагүй байна. | | | | | | | | | 1 | |
| | Нийт зөрчлийн дүн | 5 | 4,309.0 | 3 | 2,220.7 | 1 | 163.3 | 1 | 1,925.0 | 1 | |